

# МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ АШИГЛАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

## 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Харилцаа холбооны тухай хуулийн 8.1, 9.1.2 болон Зөвшөөрлийн тухай хуулийн 9.3-д заасныг тус тус үндэслэн Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид мэдээллийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч гэх/ болон Монгол Улсад мэдээллийн сүлжээ ашиглан үйлчилгээ үзүүлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, мэдээллийн сүлжээний нээлттэй байдалтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтлана.

1.2. Энэхүү журмын хүрээнд мэдээллийн сүлжээ гэдгийг харилцаа холбооны шинэ дэвшилтэд үйлчилгээ нэвтрүүлэхэд түлхэц өгөх, цахим хөгжлийг хурдасгах ач холбогдол бүхий контент түгээх сүлжээ, интернэтийн харилцан холболтын төв, Дата төв зэрэг интернэтийн дэд бүтцийг ойлгоно.

1.3. Энэхүү журмын хүрээнд интернэтэд суурилсан үйлчилгээ гэдгийг мэдээллийн сүлжээгээр дамжиж буй бүх төрлийн контент, цахим үйлчилгээ, аппликэйшн, веб сайт, сүлжээний болон хэрэглэгчийн төхөөрөмжийг ойлгоно.

1.4. Энэхүү журмыг Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид Зохицуулах хороо гэх/, интернэтийн үйлчилгээ эрхлэгч, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон мэдээллийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч /эдгээр 3 үйлчилгээ эрхлэгчийг цаашид үйлчилгээ эрхлэгч гэх/ нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

## 2. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1. Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн Зохицуулах хорооноос баталсан нөхцөл шаардлага, холбогдох журмын дагуу олгоно.

2.2. Энэхүү журмын хүрээнд мэдээллийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч гэж дараах үйлчилгээ эрхэлж буй этгээдийг ойлгоно.

2.2.1.Цахилгаан холбооны сүлжээнд холболт хийж хэрэглэгчдэд харилцаа холбооны сүлжээний дугаарлалт ашиглан мессеж, ярианы үйлчилгээ эрхэлж буй;

2.3. Зохицуулах хороо нь мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг ил тод нээлттэй байлгана.

2.4. Энэхүү журмын 2.2.1-д заасан үйлчилгээг эрхлэхэд “Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам”-ын дагуу холбогдох сүлжээний дугаарлалтыг авна.

2.5. Зохицуулах хороо зах зээл дэх өрсөлдөөний нөхцөл байдалд шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд энэхүү журамд тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2.6. Мэдээллийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсын Интернэтийн дундын холболтын төвд холбогдож болно.

## 3. МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ <sup>1</sup>НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

3.1. Хууль зөрчсөн эсхүл энэхүү журмын 3.2, 3.3-т тус тус заасны дагуу хязгаарлалт хийхээс бусад тохиолдолд үйлчилгээ эрхлэгчид нь интернэт хурдны болон технологийн бусад хязгаарлалт, нэмэлт тохируулгыг интернэтэд суурилсан үйлчилгээнд зориулан хийхгүй.

---

<sup>1</sup> ХХ-ны тухай хуулийн 16.1.Харилцаа холбооны сүлжээ нь цахилгаан холбоо, шуудан, радио, телевизийн болон мэдээллийн /интернет, компьютер зэрэг бусад/ сүлжээнээс бүрдэнэ.

3.2. Үйлчилгээ эрхлэгч нь дараах тохиолдолд интернэтэд суурилсан үйлчилгээг хаах (block), удаашруулах (discrimination), өөрчлөх (alter), хязгаарлах (restrict), саад учруулах (interfere), доройтуулах (degrade) зэрэг арга хэмжээ /цаашид сүлжээний ачааллын менежмент гэх/-г авч хэрэгжүүлж болно. Үүнд:

3.2.1. холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын хуульд нийцсэн шийдвэрийг хэрэгжүүлэх;

3.2.2. интернэтийн найдвартай, аюулгүй байдлыг хангах;

3.2.3. интернэт дамжуулж буй сүлжээний түгжрэл (internet network congestion)-ийг оновчтой зохицуулах зэрэг болно.

3.3. Үйлчилгээ эрхлэгч нь мэдээллийн сүлжээний багтаамжийн нөөцийн хэмжээ нь бусад хэрэглэгчтэй байгуулсан үйлчилгээний гэрээний үзүүлэлтийн шаардлагыг хангасан нөхцөлд сүлжээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор нэмэлт арилжааны үйлчилгээг үзүүлж болно. (managed service)

3.4. Үйлчилгээ эрхлэгч нь энэхүү журмын 3.2, 3.3-т заасан сүлжээний ачааллын менежментийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авна. Үүнд:

3.4.1. Хэрэгжүүлэх арга хэмжээний зорилго, хамрах хүрээ, нөхцөл шалтгаан, процедур, технологийн арга хэмжээг багтаасан зааврыг ил тод нээлттэйгээр өөрийн цахим хуудсанд байршуулсан байх;

3.4.2. Хэрэгжүүлэх арга хэмжээнээс шалтгаалан интернэтэд суурилсан үйлчилгээнд учрах нөлөөлөл болон дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн хэрэглэгчдэд мэдэгддэг байх;

3.4.3. Зохицуулах хорооноос гаргасан сүлжээний ачааллын менежментийн норм, норматив, стандартыг дагаж мөрдөх;

3.5. Зохицуулах хороо, үйлчилгээ эрхлэгч болон мэдээллийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч нар нь сүлжээний ачааллын менежментийн ил тод байдлыг хангах, сүлжээний чанарын хэмжилтийг техник технологийн аргаар хийхэд хамтарч ажилладаг байна.

#### **4. МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ АШИГЛАХАД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА**

4.1. Монгол Улсын Мэдээллийн сүлжээгээр дамжуулан интернэтэд суурилсан үйлчилгээг хүргэхэд дараах нийтлэг шаардлагыг хангаж ажиллана:

4.1.1. Зохицуулах хорооны 2021 оны 62 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм”-н 2.2-т заасан зохисгүй агуулгыг илэрхийлсэн аливаа төрлийн контентыг дамжуулахгүй байх;

4.1.2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн контентыг дамжуулахгүй байх;

4.1.3. Хууль зөрчсөн контентыг холбогдох эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дагуу хязгаарлах техникийн боломжийг хангасан байх;

4.1.4. хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс өөрийн үйлчилгээний талаар хэрэглэгчийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах хаяг, холбоо барих утасны дугаар болон цахим шуудангийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх;

4.1.5. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажилдаг байх;

4.1.6. интернэтэд суурилсан үйлчилгээ бүрийн тайлбар, ангилал, хэрхэн хандаж үйлчилгээ авах, үйлчилгээний төлбөрийн талаар үнэн зөв ойлгомжтой мэдээлдэг байх;

4.1.7. хэрэглэгчийн хувийн мэдээллийг зориулалтаас өөр зорилгоор хадгалах, ашиглах, хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад дамжуулахгүй байх.

## 5. ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ГОРИМ

5.1. Зохицуулах хороо энэхүү журмын 4 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас бусад заалтуудад хамаарах хяналтыг хэрэгжүүлнэ.

5.2. Зохицуулах хороо хяналтыг хэрэгжүүлэхдээ дараах арга хэрэгслийг ашиглана.

5.2.1.Хэрэглэгч, байгууллагын өргөдөл, гомдлын дагуу шалгалт хийх.

5.2.2.Үйлчилгээ эрхлэгчээс шаардлагатай мэдээ, тайлан гаргуулах;

5.2.3.Сүлжээний ачаалал, чанарын үзүүлэлтийг техник технологийн аргаар хэмжилт хийх;

5.3. Энэхүү журмын 4 дүгээр зүйлд дурдсан нийтлэг шаардлагын хяналтыг холбогдох хуульд заасан эрх бүхий хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

5.4. Энэхүү журмын 3.2.1 болон 5.3-д заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас хууль тогтоомж зөрчсөн тухай дүгнэлт, шийдвэрийг Зохицуулах хороонд ирүүлсэн тохиолдолд дараах арга хэмжээ авахыг интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэгч этгээдэд даруй мэдэгдэнэ.

5.4.1.мэдэгдэлд дурдсан контентыг эрх бүхий байгууллагаар шалгагдаж дуусах хугацаанд түр хязгаарлах;

5.4.2.мэдэгдэлд дурдсан хууль зөрчсөн контентыг устгах.

5.5. Интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэгч этгээд нь энэхүү журмын 5.4-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг мэдэгдсэнээс хойш 24 хүртэлх цагийн дотор эсхүл шаардлагатай гэж үзвэл даруй хэрэгжүүлж хариуг Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

5.6. Интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэгч этгээд нь энэ журмын 5.5-д заасан хугацаанд зөрчлийг арилгаагүй, эсхүл холбоо тогтоох боломжгүй бол дараах арга хэмжээ авах мэдэгдлийг үйлчилгээ эрхлэгчид хүргүүлж болно.

5.6.1.Интернэтэд суурилсан үйлчилгээний Монгол Улсаас хандах хандалтыг хуулийн зөрчлийг арилгах хугацаанд хязгаарлах технологийн арга хэмжээ авах;

5.7. Үйлчилгээ эрхлэгчид нь энэ журмын 5.6-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд даруй хэрэгжүүлэх үүргийг хүлээх бөгөөд хэрэгжилтийн талаарх мэдээллийг Зохицуулах хороонд цахим шуудан болон албан бичгээр ирүүлнэ.

5.8. Зохицуулах хороо нь энэ журмын 5.4-т заасан мэдэгдлийг интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэгч этгээдийн цахим орчин дахь хаяг эсхүл бүртгэлтэй цахим шуудангаар хүргүүлснээр мэдэгдсэнд тооцно.

5.9. Интернэтэд суурилсан үйлчилгээний Монгол Улсаас хандах хандалтыг сэргээхэд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.9.1.Зөрчлийг арилгасан талаарх холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг Зохицуулах хороонд ирүүлэх;

5.9.2.Зохицуулах хороо нь энэхүү журмын 5.9.1-д заасан шийдвэр, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсаас хандах хандалтыг сэргээх мэдэгдлийг үйлчилгээ эрхлэгчид даруй хүргүүлэх;

5.9.3.Үйлчилгээ эрхлэгчид нь энэхүү журмын 5.9.2-д заасан мэдэгдлийн дагуу Монгол Улсаас хандах хандалтыг сэргээх технологийн арга хэмжээг даруй авах.

5.10. Энэхүү журмын хүрээнд авсан арга хэмжээ, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийн талаар Зохицуулах хороо холбогдох талуудад тухай бүр мэдэгдэж, нэгдсэн тайланг олон нийтэд ил тод мэдээлнэ.

5.11. Хэрэв интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэгч этгээд нь тухайн контентыг хууль зөрчөөгүй гэж үзвэл тайлбарыг Зохицуулах хороонд ирүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд шүүх хяналтын байгууллагад хандаж болно.

5.12. Үйлчилгээ эрхлэгч нь энэхүү журмын 5.6-д заасан үүргийг хэрэгжүүлэх технологийн боломжийг хангасан байх бөгөөд дараах технологийн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

5.12.1.Хууль зөрчсөн домэйн нэрийн жагсаалт /black-list.mn/-ыг өөрийн сүлжээнд даруй хязгаарлах бөгөөд 8 цаг тутамд шинэчлэх;

5.12.2.домэйн нэрийн сервер болон сүлжээний хамгаалалтын төхөөрөмжийн “www.black-list.mn” домэйн нэрт харгалзах АйПи(IP) хаягаас ирэх домэйн нэрийн асуулга, хүсэлтийг зөвшөөрөх, хариулах боломжийг бүрдүүлсэн байх;

5.12.3.интернэтийн үйлчилгээнд ашиглаж буй домэйн нэрийн серверүүдийн АйПи(IP) хаягууд болон хариуцан ажилладаг ажилтны овог, нэр, албан тушаал, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг мэдээллийг Зохицуулах хороонд бүртгүүлэх;

5.13. Зохицуулах хороо нь энэхүү журмын 4.4.1-ийг зөрчсөн интернэтэд суурилсан үйлчилгээнд энэ журмын 5.6.1-т заасан арга хэмжээг шууд авч болно.

5.14. Үйлчилгээ эрхлэгч нь энэхүү журмын 5.6.1-д заасан арга хэмжээ авах тохиолдолд бусад интернэтэд суурилсан үйлчилгээний чанарт нөлөөлөхөөр бол энэ тухай тайлбарыг Зохицуулах хороонд ирүүлж болно.

## **6. ГОМДОЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

6.1. Гомдол, маргаантай асуудлыг маргалдагч талууд шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Зохицуулах хороонд хандаж болно.

6.2. Харилцаа холбооны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийн хүрээнд тухайн гомдол, маргааныг шийдвэрлэхдээ Зохицуулах хорооноос баталсан “Гомдол, маргааныг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг мөрдлөг болгоно.

## **7. ХАРИУЦЛАГА**

7.1. Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.